



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/648


Улаанбаатар хот

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хаяг өөрчлөх, хугацаа сунгах болон сэргээх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, 10.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хаяг өөрчлөх, хугацаа сунгах, сэргээх байгууллагуудын нэрсийг хавсралтаар баталсугай.
2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т үүрэг болгосугай.

САЙД



С.ЭНХБОЛД

Эрүүл мэндийн сайдын 2021 оны
дугаар сарын 28 - ны өдрийн
дугаар тушаалын хавсралт



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАХ, ХАЯГ ӨӨРЧЛӨХ, БОЛОН СЭРГЭЭХ
БАЙГУУЛЛАГУУДЫН НЭРС:**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах байгууллага				
1.	Ливер центр ХХК “Элэгний төв” эмнэлэг	Лабораторийн тусламж үйлчилгээ	СБД 1-р хороо, Юнеско гудамж 31, Далай цамхаг 2 давхарт	2026.07.21
Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, хаяг өөрчлөх байгууллага				
2.	Биг Виг ХХК	Эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез импортлох, ханган нийлүүлэх	ХУД, 20-р хороо, Үйлдвэр 2 Шарав гудамжны 26 тоот	2026.10.01
Тусгай зөвшөөрлийн хаяг өөрчлөх байгууллага				
3.	Баясгалантай Дэлхий ХХК	Дотор, эмэгтэйчүүд, уламжлалт, сэргээн засах, дүрс оношилгоо, эмэгтэйчүүд, арьс харшил, проктологийн тусламж үйлчилгээ	ХУД, 17-р хороо, Стадион оргил /17012/ Богд Жавзандамба гудамж 34-3 тоот	2023.09.21
Тусгай зөвшөөрлийн эрх сэргээж, хаягийн өөрчлөх байгууллага				
4.	Юу би өү эс эс ти и эм ХХК-ний UB OSSTEM шүдний эмнэлэг	Шүдний оношлогоо, эмчилгээ, зөвлөгөө, эрүү нүүрний мэс засал, хиймэл шүдний чиглэлээр тусламж үйлчилгээ	БЗД, 26-р хороо, Сакура тауэр 2 давхар	2025.10.28